



Интернэтийн үйлчилгээ үзүүлэх гэрээ

№

..... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “ЭЙЧ ЭН АЙ” ХХК /цаашид “Үйлчилгээ үзүүлэгч” гэх/-г төлөөлж тус компанийн Гүйцэтгэх захирал албан тушаалтай нөгөө талаас цаашид “Үйлчлүүлэгч” гэх/-г төлөөлж албан тушаалтай нар /хамтад нь “Талууд” гэх/ өндөр хурдны интернэтийн үйлчилгээ авахаар дараах нөхцлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Үйлчилгээ үзүүлэгч нь интернэтийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг үйлчлүүлэгчийн талд суурилуулж, тохирох холболтуудыг хийж өгөх бөгөөд үйлчлүүлэгч тал зохих төлбөр тооцоог төлөхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулахад энэхүү гэрээнд заасан дараахи нөхцөлүүдийн зорилго оршино.

ХОЁР. ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс ... оны ... дүгээр сарын ...-ийг дуустал хуанлийн тооллоор нэг (1) жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.
- 2.2 Талуудын аль нэг нь гэрээ дуусахаас нэг (1) сарын өмнө уг гэрээг цуцлах, цаашид үйлчилгээг дуусгавар болгох талаар албан бичгээр мэдэгдэл гаргаагүй бол гэрээний үйлчлэх хугацааг дахин нэг (1) жилийн хугацаатай сунгагдсанд тооцно.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 3.1 Үйлчилгээний сарын төлбөрийг энэхүү гэрээний 3.4т заасан тарифын дагуу тооцно.
- 3.2 Нэмэлт үйлчилгээний төлбөрийг хавсралтад заасан тарифаар тооцно.
- 3.3 Үйлчлүүлэгч холболтын хураамжийг зөвхөн нэг удаа гэрээ хийхийн өмнө төлнө.
- 3.4 Үйлчлүүлэгч албан байгууллагад зориулсан / ... **mbps** / интернэт үйлчилгээний 1 сарын төлбөр /...../ бичгээр / / төгрөгийг үйлчилгээ үзүүлэгч талд урьдчилсан төлбөрт хэлбэрээр төлнө.
- 3.5 Төлбөрийг үйлчлүүлэгч тал үйлчилгээ үзүүлэгч талын нэхэмжлэлийг үндэслэн сар бүрийн 10-ны дотор үйлчилгээ үзүүлэгч талын дараах дансуудад хийнэ.
 - “Эйч Эн Ай” ХХК Хаан Банк Дансны дугаар: 5024085142 (MNT)
 - “Эйч Эн Ай” ХХК Голомт Банк Дансны дугаар: 2205012124 (MNT)
- 3.6 Үйлчлүүлэгч Үйлчилгээ үзүүлэгчийн нэхэмжилсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хэтэрсэн өдөр тутам нэхэмжлэгдсэн төлбөрийн 0.1% хувьтай тэнцэх хэмжээний алданги тооцож үндсэн төлбөр дээр нэмж төлнө.

- 3.7 Талууд харилцан тохиролцсон тохиолдолд үйлчлүүлэгч гэрээний нийт хугацааны үйлчилгээний төлбөрийг нэгтгэн төлж болно.
- 3.8 Үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр түр хугацаагаар зогсоох тохиолдолд үйлчилгээний хураамжаас чөлөөлнө.
- 3.9 Үйлчлүүлэгч төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлбөрөө бүрэн төлөх хүртэл үйлчилгээг түр хугацаагаар салгаж болно. Хугацаанд нь төлөөгүйгээс болж салгагдсан өдрүүдийн төлбөрөөс чөлөөлөхгүй.

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Үйлчлүүлэгчийг хавсралтад заасан техникийн нөхцөлийн дагуу интернэтэд холбогдох, үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээг ашиглан интернэтээс хэрэгцээт мэдээллээ авах боломжийг бүрдүүлнэ.
- 4.2 Тухайн үед мөрдөж буй журам, үнэ тарифын дагуу үйлчилгээг хурдан шуурхай үзүүлнэ.
- 4.3 Үйлчлүүлэгч нэгээс дээш компьютерт интернэтийн холболт хийлгэж буй нөхцөлд үйлчилгээ үзүүлэгч зөвхөн толгой компьютерт холболт хийнэ. Дотоод сүлжээнд холбох асуудлыг шийдэхгүй.
- 4.4 Үйлчилгээний нөхцөл, тарифт өөрчлөлт орж болох бөгөөд энэ тухайгаа Үйлчлүүлэгчид нэг (1) сарын өмнө мэдэгдэнэ.
- 4.5 Төлөвлөгөөт техникийн засвар, шинчлэлтийн үйлчилгээг жилд 4-өөс дээшгүй удаа интернэтийг 2 цагаас ихгүй хугацаанд тасалдуулж хийнэ. Ажлыг гүйцэтгэхдээ 24-с доошгүй цагийн өмнө мэдэгдэж Үйлчлүүлэгчийн илүү тохиромжтой үед явуулах ба энэ хугацаа ҮЙЛЧИЛГЭЭ тасалдсанд тооцогдохгүй.
- 4.6 Техникийн болон холболтын шинэчлэл хийх зайлшгүй шаардлагатай үед Үйлчлүүлэгчид 24 цагийн өмнө урьдчилан мэдэгдэж, холболтыг түр хугацаагаар таслах эрхтэй.
- 4.7 Сүлжээнд гэнэтийн осол гарсан үед Үйлчилгээ үзүүлэгч Үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авалгүйгээр засварын ажлыг яаралтай эхлэх эрхтэй.
- 4.8 Үйлчлүүлэгч гэрээний нөхцлийг зөрчсөн тохиолдолд үйлчилгээг түр хаах буюу гэрээг цуцлах эрхтэй.
- 4.9 Үйлчлүүлэгчийн талд үйлчилгээ тасалдсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгч хоёр (2) цагийн дотор үйлчилгээг сэргээхийн тулд бүх хүчээ дайчилна.
- 4.10 Үйлчилгээ үзүүлэгч нь ажлын өдрүүдийн 09:00-21:00 цагийн хооронд Үйлчлүүлэгчээс үйлчилгээний тухай гомдол хүлээн авах тохиолдолд 4 цагт багтааж асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, Үйлчлүүлэгчид шаардлагатай техникийн болон хэрэглээний зөвлөгөө өгнө.
- 4.11 Үйлчлүүлэгчийн талд гарсан үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалсан гэмтэл саатлыг үйлчлүүлэгчийн талд очиж үнэ төлбөргүй засварлах бөгөөд үйлчилгээ үзүүлэгчээс шалтгаалаагүй тохиолдолд тарифын дагуу нэмэлт төлбөрийг нэхэмжилнэ. Энэ тохиолдолуудад харилцан холболтын цэгээс үйлчлүүлэгчийн талд гарсан буюу :
- IP хаяг болон MAC хаягийг зөвшөөрөлгүй өөрчилсөн
 - Компютерүүдийн тохиргоотой хамааралтай
 - Дотоод сүлжээтэй хамааралтай

ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Үйлчлүүлэгч үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлж өөрийн талд үйлчилгээ үзүүлэгчээс хамаарсан гэмтэл гарсан үед дуудлага өгч үнэ төлбөргүй засварлуулах эрхтэй.

- 5.2 Хүндэтгэх шалтгааны улмаас түр хугацаагаар үйлчилгээг зогсоох хүсэлт тавих эрхтэй бөгөөд энэ тухайгаа нэг(1)долоо хоногоос багагүй хугацааны өмнө Үйлчилгээ үзүүлэгчид бичгээр мэдэгдэнэ.
- 5.3 Үйлчилгээ үзүүлэгчийн төлөвлөгөөт болон гэнэтийн техникийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчийн үйлчилгээг таван (5) цагаас илүү хугацаанд тасалдуулсан бол уг тасалдсан хугацааг нэг (1) өдрөөр тооцож хоног нэмж өгнө.
- 5.4 Үйлчлүүлэгч, Үйлчилгээ үзүүлэгчийг тоног төхөөрөмжийн суурилуулалт, хэмжилт болон засварын ажил хийх үед саадгүй нэвтрэх, ажиллах боломжоор бүрэн хангах үүрэгтэй.
- 5.5 Үйлчлүүлэгч нь холболтын төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах цахилгаан тэжээл болон бусад техникийн нөхцөлөөр хангах үүрэгтэй.
- 5.6 Үйлчлүүлэгч гэрээгээр тохиролцсон төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй. Төлбөрийн баримт дээр хэрэглэгчийн нэрээ заавал бичнэ.
- 5.7 Гэрээний хугацаа дууссан, гэрээг цуцалсан тохиолдолд төлбөрийг бүрэн барагдуулж үйлчилгээ үзүүлэгч талтай тооцоо нийлж гэрээг дуусгах үүрэгтэй.
- 5.8 Хэрэв Интернэт хэвийн, шилэн кабелиас үүдэлтэй гэмтэл гарсан тохиолдолд энэ тухай шуурхай “Эйч Эйн Ай” ХХК-д цаг алдалгүй мэдэгдэж хамтран ажиллан асуудлыг шийднэ.
- 5.9 Үйлчлүүлэгч өөрийн интернэтийн хурдыг speedtest.net гэсэн вэб хуудасаар дамжуулан Үйлчлүүлэгч нь интернэтийн үйлчилгээ авч байх хугацаандаа Монгол улсын хууль тогтоомжын дагуу ашиглах үүрэгтэй.

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХАРИУЦЛАГА

- 6.1 Үйлчилгээ үзүүлэгч Үйлчлүүлэгчийн дотоод сүлжээг гадны халдлагаас (Троян, вирус, серверийн халдлага г.м) хамгаалах үүргийг хүлээхгүй.
- 6.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчлүүлэгч талд тасралтгүй буюу 24/7 хугацаанд интернэтийн урсгалыг тогтмол үзүүлэх.
- 6.3 Дараах тохиолдлуудаас шалтгаалж үйлчилгээ тасалдвал Үйлчилгээ үзүүлэгч хариуцлага хүлээхгүй.
 - 6.3.1 Байгалийн гамшиг, бослого, ажил хаялт, дайн, засгийн газрын шийдвэр, хувьсгал зэрэг давтагдашгүй хүчин зүйлийн үйлчлэл.
 - 6.3.2 Гал түймэр, тог тэжээлийн тасалдал, тогтворгүй байдлаас хамаарсан болон үйлчлүүлэгч төхөөрөмжийг буруу ашигласан.
 - 6.3.3 Үйлчлүүлэгчийн санаатай буюу хорон үйл ажиллагаанаас болсон.
 - 6.3.4 Үйлчлүүлэгч төхөөрөмжийн хэвийн ажиллах горимыг алдагдуулсан.
 - 6.3.5 Гадаад гарц, үндсэн ISP компаниас үүсэлтэй гэнэтийн тасалдал зэрэг хамаарна.

ДОЛОО. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ХАРИУЦЛАГА

- 7.1 Үйлчлүүлэгч өөрийн компьютерийн дотоод сүлжээ, мэдээлэлийн аюулгүй байдал, хэрэглэгчийн нууц дугаар, компьютерийн вирус, гадна халдлагаас хамгаалах асуудалаа өөрөө бие даан хариуцна.
- 7.2 Үйлдвэрийн гэмтэл согоогоос шалтгаалан төхөөрөмж эвдэрсэн бол (Үйлчилгээ үзүүлэгчийн мэргэжилтнүүд шалгаж, баталсан тохиолдолд) үйлчлүүлэгч хариуцлага хүлээхгүй.
- 7.3 Үйлчлүүлэгч түрээсээр эзэмшиж буй тохиолдолд сурилуулсан тоног төхөөрөмжүүдийн хадгалалт, хамгаалалт бүрэн бүтэн байдалд анхаарал тавих бөгөөд бүрэн хариуцана.
- 7.4 Интернэтийг хууль бусаар ашигласан эсхүл интернэт орчинд хууль бус мэдээ мэдээлэл тараасан, хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргасан тохиолдолд түүнээс гарсан үр дагавар, хариуцлагыг үйлчлүүлэгч бие даан хариуцаж хүлээнэ.

- 7.5 Гэрээнд заагдсан шилэн кабелийн суурилуулалтын ажил хийгдэж байх хугацаанд тодорхой шалтгааны улмаас үйлчлүүлэгч тал суурилуулалтыг зогсоох, гэрээг цуцлахыг хүсвэл 3.3-д заасан суурилуулалтын зардлын 70%-ийг Үйлчлэгч талд төлнө.
- 7.6 Үйлчлүүлэгч нь гэрээн дэх шилэн кабель холбосон цэгийг хугацаанаас нь өмнө 1 жилийн дотор цуцалсан тохиолдолд гэрээ дуусах өдрийг хүртэлх тухайн шилэн кабелийн түрээсийн сарын суурь хураамжийн 50%-ийн алдангийг тооцож Үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

НАЙМ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 8.1 Үйлчлүүлэгч үйлчилгээ авахаас татгалзаж уг гэрээг цуцлах хүсэлтэй байгаа бол түүнийгээ нэг (1) сарын өмнө албан бичгээр илэрхийлнэ.
- 8.2 Үйлчилгээ үзүүлэгч уг хүсэлтийг үйлчилгээ авахаас татгалзсан мэдэгдэл ирснээс хойш нэг (1) сарын дотор шийдвэрлэнэ.
- 8.3 Үйлчлүүлэгч гэрээний хугацаа дуусахаас өмнө уг гэрээг цуцлах тохиолдолд хэрэглэсэн үйлчилгээнийхээ төлбөрийг бүрэн төлсөн байна.
- 8.4 Үйлчлүүлэгч тал дампуурсан тохиолдолд Үйлчилгээ үзүүлэгчид гэрээ цуцлах талаар мэдэгдэх бөгөөд төлөгдөөгүй байгаа төлбөрийг дуусгавар болгоно.
- 8.5 Үйлчлүүлэгч урьдчилж төлсөн төлбөрийн үлдэгдэлийг буцаах тохиолдолд үлдэгдэл төлбөрөөс 20%-ийн шимтгэл ноогдуулна.

ЕС. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 9.1 Талууд гэрээнд заагдсан бүх заалтуудыг чандлан мөрдөнө.
- 9.2 Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад талуудын хооронд гарах аливаа маргааныг эсрэг талынхаа хаягруу нь албан бичгээр мэдэгдэнэ.
- 9.3 Талуудын хооронд бий болсон аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжын дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД

- 10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ.
- 10.2 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр өөрчлөлтийг гэрээнд хавсралтаар оруулах бөгөөд хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 10.3 Энэхүү гэрээ 2 хувь үйлдэгдэх бөгөөд хувь тус бүр хууль зүйн хүрээнд адил хүчинтэй байна.
- 10.4 Энэхүү гэрээнд заагдаагүй аливаа асуудлуудыг Монгол Улсын хуулийн хүрээнд шийдвэрлэнэ.

АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

“Эйч Эн Ай” ХХК

Монгол Улс, Улаанбаатар-43
Сүхбаатар дүүрэг Оюутны гудамж
НОМОНЕТ байр, 1 давхар

Утас: (976)-11331304.

Факс: (976)

И-мэйл: info@homenet.mn

Веб сайт: www.homenet.mn

.....
.....
.....

Утас: (976)-

Факс: (976)-

И-мэйл:

Вэб сайт:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Эйч Эн Ай ХХК-г төлөөлж:

Гүйцэтгэх захирал

Үйлчлүүлэгчийг төлөөлж:

Гарын үсэг _____

Тамга

Гарын үсэг _____

Тамга

Хэрэглэгчийн үндсэн мэдээлэл

Байгууллагын нэр

Улсын бүртгэлийн дугаар:.....Регистерийн дугаар:

Байгууллагын албан хаяг:

Байгууллагын албан бус хаяг:

Утасны дугаар: Имэйл хаяг:

Авч буй үйлчилгээ: Хурд: ...Mbps /shared/ Үнэ:төг

Нэхэмжлэх авах хэлбэр: Мэссэж / Имэйл (доогуур зурна уу.)

Харилцах хүмүүс:

Удирдлага:

нэр: утас: имэйл:.....

Инженер техник:

(1) нэр: утас: имэйл:

(2) нэр: утас: имэйл:

Санхүү:

нэр: утас: имэйл:

Тусгай тэмдэглэл:

Үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр: Эйч Эн Ай ХХК

Байгууллагын албан хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Оюутны гудамж

16/3, Номenet байр

Харилцах хүмүүс:

Инженер техник:

Нэр: Б.Отгонболор утас: 11331304 гар утас: 94110522 имэйл: info@homenet.mn

Санхүү:

Нэр: О.Доржханд утас: 11331304 гар утас: имэйл: info@homenet.mn